

2023 он 11 сар 15 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот


**Азийн Хөгжлийн Банкнаас зээл авах зөвшөөрөл олгох,
дэмжин баталгаажуулах тухай**

“Говь” ХК (“Компани” гэх) нь эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн зорилгоор Азийн Хөгжлийн Банк (“АХБ”) -аас зээл авах тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16, 76.1.18 дахь хэсэг, Компанийн дүрмийн 6.2.7.14, 6.2.7.17 дахь заалтыг удирдлага болгон Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. АХБ-наас 30,000,000 (гучин сая) ам.долларын зээлийг [3] жилийн хугацаатай, дунджаар [USD Floating: 3.89%+ “Secured Overnight Financing rate”, USD Fixed: 3.89%+ “Swap rate”] %-ийн жилийн хүүтэйгээр зээлж, зохих зээлийн гэрээг байгуулахыг Компанид зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын Хавсралт 1-д заасан хөрөнгийг АХБ-наас авах зээлийн үүргийн гүйцэтгэлийн баталгаа болгож барьцаанд тавих, барьцаа хөрөнгө нэмэгдүүлэх бол өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх, мөн дараахь барьцааны гэрээнүүдийг байгуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д олгосугай, үүнд: (i) үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ (газар), (ii) үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ (барилга), (iii) хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ, (iv) (АХБ-наас нэмж шаардах тохиолдолд) хувьцааны барьцааны гэрээ.
3. Энэхүү тогтоолын 1,2 дахь заалтад дурдсан, АХБ-тай байгуулах гэрээнүүд болон холбогдох бусад гэрээ, баримт бичгийн нөхцөл агуулгыг Компанийн нэрийн өмнөөс хэлэлцэн тохиролцож, улмаар Компанийг төлөөлж гарын үсэг зурж, баталгаажуулах, эдгээр гэрээтэй холбоотой мэдэгдэл, баталгаа, гэрчилгээ, маягт, бусад баримт бичигт гарын үсэг зурах, холбогдох төлбөр тооцоог хийх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д олгосугай.
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, Гүйцэтгэх захирлын баталсан, гаргасан бүх шийдвэр, үйлдэл нь энэхүү тогтоол батлагдсан өдрийн байдлаар хүчин төгөлдөр болохыг үүгээр дэмжин баталгаажуулсугай.

ТУЗ-ийн ДАРГА:

ТУЗ-ийн ГИШҮҮД:




Д.ГЭРЭЛМАА

Ц.БААТАРСАЙХАН

20.23 он .11 сар .15 өдөр

Дугаар .34

Улаанбаатар хот

 Б.АМАРСАЙХАН

 Ц.ОРГИЛБОЛД

А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

 Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР

20.23 он 11 сар 15 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

 Б.АМАРСАЙХАН

 Ц.ОРГИЛБОЛД

А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР

